



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

БАЙГАЛЬ ОРЧИН - ЭДИЙН ЗАСГИЙН ДАНС

ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНС 2020-2023

Улаанбаатар хот
2024 он



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

БАЙГАЛЬ ОРЧИН-ЭДИЙН ЗАСГИЙН ДАНС:
ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНС
2020-2023

Улаанбаатар хот
2024 он

ТАНИЛЦУУЛГЫГ ХЯНАСАН:

Б.Батдаваа	ҮСХ-ны дарга
Д.Лхамсүрэн	ҮСХ-ны дэд дарга
Ц.Тэгшжаргал	Нэгдсэн статистикийн газрын дарга

ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:

Ж.Тэрбиш	Үндэсний тооцооны хэлтсийн дарга
----------	----------------------------------

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот

Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,

Засгийн газрын III байр, 14200

Утас: 7014-1212

Цахим хуудас : www.nso.mn, www.1212.mn

И-мэйл: information@nso.mn

АГУУЛГА

ОРШИЛ.....	5
НЭГ. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНЫ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ	6
1.1. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН НӨӨЦ, АШИГЛАЛТЫН ХҮСНЭГТ	6
1.2. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	6
ХОЁР. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНЫ ҮР ДҮН	8
2.1. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН НИЙТ НӨӨЦ.....	8
2.1.1. ЭНГИЙН ХОГ ХАЯГДАЛ.....	8
2.1.2. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ.....	9
2.1.3. ХОГ ХАЯГДАЛ, эдийн засгийн салбараар	10
2.2. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН НИЙТ АШИГЛАЛТ	11
2.2.1. ДАХИН АШИГЛАСАН, БОЛОВСРУУЛСАН ЭНГИЙН ХОГ ХАЯГДАЛ.....	12
ГУРАВ. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	13
3.1. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНААС ТООЦСОН ТХЗ-ЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	13
ДҮГНЭЛТ	14
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	16

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. ХОГ ХАЯГДЛЫН НӨӨЦИЙН ХҮСНЭГТИЙН ХЯЛБАРШУУЛСАН ЗАГВАР	6
ХҮСНЭГТ 2. ХОГ ХАЯГДЛЫН АШИГЛАЛТЫН ХҮСНЭГТИЙН ХЯЛБАРШУУЛСАН ЗАГВАР	6
ХҮСНЭГТ 3. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН НИЙТ НӨӨЦ, ЭХ ҮҮСВЭРЭЭР, МЯНГАН ТОНН	8
ХҮСНЭГТ 4. ЭНГИЙН ХОГ ХАЯГДАЛ, ХОГ ХАЯГДЛЫН ТӨРЛӨӨР, МЯНГАН ТОНН.....	8
ХҮСНЭГТ 5. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ, ЭХ ҮҮСВЭРЭЭР, МЯНГАН ТОНН	10
ХҮСНЭГТ 6. ААНБ-Д БИЙ БОЛСОН ХОГ ХАЯГДАЛ, ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРААР, МЯНГАН ТОНН	11
ХҮСНЭГТ 7. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН НИЙТ АШИГЛАЛТ, МЯНГАН ТОНН.....	11
ХҮСНЭГТ 8. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН НИЙТ АШИГЛАЛТ, ХОГ ХАЯГДЛЫН ТӨРЛӨӨР, МЯНГАН ТОНН..	12
ХҮСНЭГТ 9. ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН ДАХИН АШИГЛАЛТ, БОЛОВСРУУЛАЛТ, ХОГ ХАЯГДЛЫН ТӨРЛӨӨР, МЯНГАН ТОНН	12
ХҮСНЭГТ 9. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНААС ТООЦСОН ТХЗ-ЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	14

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН БҮТЭЦ, ХУВИАР, 2023 ОН	9
ЗУРАГ 2. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН БҮТЭЦ, ЭХ ҮҮСВЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР	10
ЗУРАГ 3. ДАХИН БОЛОВСРУУЛСАН, АШИГЛАСАН ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН БҮТЭЦ, ХУВИАР..	13

ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хавсралт 1. Хатуу хог хаягдлын нөөцийн хүснэгт, 2020 он	
Хавсралт 2. Хатуу хог хаягдлын ашиглалтын хүснэгт, 2020 он	
Хавсралт 3. Хатуу хог хаягдлын нөөцийн хүснэгт, 2021 он	
Хавсралт 4. Хатуу хог хаягдлын ашиглалтын хүснэгт, 2021 он	
Хавсралт 5. Хатуу хог хаягдлын нөөцийн хүснэгт, 2022 он	
Хавсралт 6. Хатуу хог хаягдлын ашиглалтын хүснэгт, 2022 он	
Хавсралт 7. Хатуу хог хаягдлын нөөцийн хүснэгт, 2023 он	
Хавсралт 8. Хатуу хог хаягдлын ашиглалтын хүснэгт, 2023 он	

ОРШИЛ

Улс орнуудын эдийн засгийн үйл ажиллагаа нь байгаль орчинд ихээхэн нөлөөлдөг бол эдийн засгийн өсөлт, хүний сайн сайхан байдал нь байгаль орчны үр өгөөжөөс хамаардаг. Хурдацтай хөгжиж буй эдийн засгийн үйл ажиллагаа, үйлдвэржилт нь уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал, бохирдол, байгалийн нөөцийн хомсдол, цөлжилт, биологийн төрөл зүйл алдагдах, хог хаягдал нэмэгдэх зэргээр байгаль орчны олон сөрөг асуудлыг үүсгэж байна.

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (2015) -ийн мэдээлснээр 21-р зууны эцэс гэхэд дэлхийн хүн ам 11 тэрбум болж, хүн амын 80 хувь нь хотод амьдрах төлөвтэй байна. Хүн амын өсөлт, хотжилт, амьжиргааны түвшний өөрчлөлтүүд нь эдийн засгийн салбар, өрхөөс үүсэх хатуу хог хаягдлын тоо хэмжээ, түүний төрөл зүйл нэмэгдэхэд ихээхэн хувь нэмэр оруулж байна.

Хог хаягдлын зохисгүй менежмент нь хөрс, ус, агаарын бохирдол, уур амьсгалын өөрчлөлт, газрын ашиглалтаар дамжуулж хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, ил задгай хаясан болон шатаасан хог хаягдал нь тоосонцор болон удаан хадгалагдах органик бохирдуулагчийг их хэмжээгээр ялгаруулж хүрээлэн буй орчинд шууд, хүний эрүүл мэндэд шууд бусаар хор хөнөөл учруулдаг.

Хог хаягдлын хэмжээ нь хүн амын хэрэглээ, үйлдвэрлэлийн хэв маягтай нягт холбоотой. Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого”, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичигт хог хаягдлын дахин боловсруулах хэмжээг 2025 онд 30 хувь, 2030 онд 40 хувьд хүргэх зорилтыг дэвшүүлсэн. Хатуу хог хаягдлын зохистой менежментгүйгээр эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэх боломж хомс юм.

Тиймээс хог хаягдлын менежментийг сайжруулах, бодлого, шийдвэр гаргахад хог хаягдлын нарийвчилсан дэлгэрэнгүй тоо мэдээллийн хэрэгцээ шаардлага гарч байна. Хог хаягдлын дансыг байгуулснаар хог хаягдлын хэмжээ, эх үүсвэр, төрөл зүйл, үүссэн хог хаягдлын ашиглалт, байгаль орчинд хаягдаж байгаа хэмжээ зэрэг мэдээллийг нэгтгэн харах боломжтой.

Хог хаягдлын данс нь тогтвортой хөгжлийн зорилтын дараах үзүүлэлтүүдийг тооцох, үнэлэх мэдээллийн эх үүсвэр болно. Үүнд:

Зорилт 11.6.1 Хот суурин газарт бий болсон хатуу хог хаягдлаас эцсийн боловсруулалт хийгдсэн хатуу хог хаягдлын эзлэх хувь;

Зорилт 12.4.2 Нийт аюултай хог хаягдалд эцсийн боловсруулалт хийсэн аюултай хог хаягдлын эзлэх хувь;

Зорилт 12.5.1 Хог хаягдлын дахин боловсруулалтын түвшин

Энэхүү танилцуулгын эхний хэсэгт хатуу хог хаягдлын дансны талаарх ерөнхий ойлголт, 2 дугаар хэсэгт Монгол Улсын хатуу хог хаягдлын дансны 2020-2023 оны гүйцэтгэлийн үр дүн, 3 дугаар хэсэгт данснаас тооцсон тогтвортой хөгжлийн зорилтын холбогдох үзүүлэлтийн дүнг, Дүгнэлт хэсэгт хатуу хог хаягдлын 2020-2023 оны дансны гол үр дүнг харууллаа.

НЭГ. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНЫ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

1.1. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН НӨӨЦ, АШИГЛАЛТЫН ХҮСНЭГТ

Хатуу хог хаягдлын данс нь нөөцийн болон ашиглалтын гэсэн 2 хүснэгтээс бүрдэх ба нөөцийн хүснэгт нь эдийн засгийн салбарууд болон өрхийн үйлдвэрлэл, хэрэглээний явцад үүссэн хог хаягдал, импортоор оруулсан хог хаягдлыг бүртгэнэ.

ХҮСНЭГТ 1. ХОГ ХАЯГДЛЫН НӨӨЦИЙН ХҮСНЭГТИЙН ХЯЛБАРШУУЛСАН ЗАГВАР

Хатуу хог хаягдлын эх үүсвэр - Дотоод					Өрх	Гадаад эдийн засаг	НИЙТ НӨӨЦ
Эдийн засгийн салбарууд						Хатуу хог хаягдлын импорт	
ХАА	Уул уурхай	Боловс- руулах	Үйлчилгээ				
Хатуу хог хаягдал, төрлөөр							

Ашиглалтын хүснэгт нь бий болсон хог хаягдлын ашиглалт буюу менежментийг харуулах ба устгасан, газарт булшилсан, шатаасан, дахин боловсруулсан, дахин ашигласан, экспортлосон, байгаль орчинд шууд хаягдсан хог хаягдлыг бүртгэнэ.

Хатуу хог хаягдлын дансыг биет хэмжээгээр байгуулах ба хэмжих нэгж нь тонн байна.

ХҮСНЭГТ 2. ХОГ ХАЯГДЛЫН АШИГЛАЛТЫН ХҮСНЭГТИЙН ХЯЛБАРШУУЛСАН ЗАГВАР

Хог хаягдлыг зайлуулах, устгах, боловсруулах					Гадаад эдийн засаг	Байгаль орчинд орох урсгал	НИЙТ АШИГЛАЛТ
Ландфилл /газарт булшлах/	Шатаах	Бусад	Дахин ашиглах, боловсруул ах	Хатуу хог хаягдлын экспорт			
Хатуу хог хаягдал, төрлөөр							

Хатуу хог хаягдлын дансны мэдээллийн үндсэн эх үүсвэр нь БОУАӨЯ-ны захиргааны статистик мэдээлэл болох “Энгийн хатуу хог хаягдлын жилийн мэдээ - БОХ 6.1”, “Аюултай хог хаягдлын жилийн мэдээ - БОХ 6.2”, “Хог хаягдлын дахин ашиглалт, боловсруулалтын жилийн мэдээ - БОХ 6.3” маягтаар цуглуулсан мэдээлэл байна.

Хог хаягдлын нөөц, ашиглалтын хүснэгтийг байгуулахдаа аж ахуйн нэгж байгууллагын өртөг, зардлын судалгаа, ДНБ, хүн амын тоо, өрхийн хэрэглээ зэрэг мэдээллийн бусад эх үүсвэрийг ашиглана. Хатуу хог хаягдлын экспорт, импортын мэдээллийг гадаад худалдааны гаалийн статистик мэдээллээс авна.

1.2. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Хог хаягдал	Өмчлөгч этгээд хэрэглэхгүй болсон эд юмс, материалыг хэлнэ.
Аюултай хог хаягдал	Тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа

	аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг хэлнэ.
Энгийн хог хаягдал	Аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг ойлгоно.
Хог хаягдал цуглуулах	Хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, шатаах, устгах, булшлах зорилгоор эх үүсвэрээс төвлөрүүлэхийг хэлнэ.
Хог хаягдал ангилах	Хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, шатаах, устгах, булшлах зорилгоор төрөлжүүлэн ялгахыг хэлнэ.
Хог хаягдал хадгалах	Байгаль орчин, хүн амьтанд сөрөг нөлөөлөлгүйгээр хог хаягдлыг савлаж байршуулахыг хэлнэ.
Ландфилл	Хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр газарт булшилж хадгалах байгууламжийг хэлнэ.
Хог хаягдлыг устгах	Хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх зорилгоор ландфиллд булшлах, биологийн болон хими, физикийн аргаар боловсруулах, шатаах, халдваргүйжүүлэх, савлаж хадгалахыг хэлнэ.
Хог хаягдлыг булшлах	Хог хаягдлыг газарт булж хадгалахыг хэлнэ.
Хог хаягдлыг шатаах	Хог хаягдлыг зориулалтын байгууламжид шатааж задлахыг хэлнэ.
Хог хаягдлыг ил шатаах	Хог хаягдлыг ил задгай, зориулалтын бус байгууламжид шатаахыг хэлнэ.
Хог хаягдал дахин боловсруулах	Хог хаягдлаас шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг хэлнэ.
Хог хаягдал дахин ашиглах	Ашиглагдаж байсан зорилгоор нь хог хаягдлыг эргүүлэн хэрэглээнд оруулахыг хэлнэ.
Хог хаягдал сэргээн ашиглах	Хог хаягдлаар эрчим хүч үйлдвэрлэх, эсхүл нэрэх, цэвэрлэх, сэргээх зэрэг аргаар анхны хэлбэрт оруулж, ашиглахыг ойлгоно.
Дахивар нөөц	Дахин ашиглагдах, дахин боловсруулах, сэргээн ашиглагдах хог хаягдлыг хэлнэ.
Ахуйн хог хаягдал	Айл өрхөөс гарах энгийн хог хаягдлыг хэлнэ.
Биологийн боловсруулалт	Бичил биетээр бохирдуулагчийг устгах болон хоргүйжүүлэхийг ойлгоно.
Хими-физикийн боловсруулалт	Химийн болон физикийн боловсруулалтыг хослуулан хэрэглэхийг хэлнэ.
Химийн боловсруулалт	Химийн бодис ашиглаж хоргүйжүүлэхийг ойлгоно.
Физикийн боловсруулалт	Шүүх, тунадасжуулах, шингээх, нэрэх зэрэг аргаар бохирдуулагчийг цэвэрлэхийг хэлнэ.
Халдваргүйжүүлэх	Химийн болон физикийн аргаар халдвартай бичил биетийг устгахыг хэлнэ.
Аюултай хог хаягдал үүсгэгч	Үйл ажиллагаа болон үйлдвэрлэлээс нь аюултай хог хаягдал үүсдэг аж ахуйн нэгж, байгууллагыг хэлнэ.
Аюултай хог хаягдал тээвэрлэгч	Аюултай хог хаягдлыг үүсгэгч болон өмчлөгчөөс тээврийн хэрэгслээр хүлээн авагчид хүргэх үйл ажиллагаа эрхлэгчийг хэлнэ.

ХОЁР. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНЫ ҮР ДҮН

2.1. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН НИЙТ НӨӨЦ

Хатуу хог хаягдлын нийт нөөц 2023 онд 3 042.9 мянган тонн болж, 2022 онтой харьцуулахад 25.0 мянган тонн буюу 0.8 хувиар буурсан байна. Энэхүү бууралтад ААНБ-д бий болсон аюултай хог хаягдлын хэмжээ буурсан нь нөлөөлсөн. Нийт хог хаягдалд ААНБ-ын хог хаягдал 39.5 хувь, өрхийн хог хаягдал 60.4 хувь, импорт 0.1 хувийг тус тус эзэлж байна.

ААНБ-д бий болсон хог хаягдал 2023 онд 1 201.9 мянган тонн болж, 2022 оноос 109.0 (8.3%) мянган тонноор буурахад аюултай хог хаягдлын хэмжээ 133.5 (23.6%) мянган тонноор буурсан нь нөлөөлсөн. Харин өрхөд бий болсон хог хаягдлын хэмжээ 2023 онд 1 839.0 мянган тонн болж өмнөх оноос 85.0 (4.8%) мянган тонноор нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 3. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН НИЙТ НӨӨЦ, эх үүсвэрээр, мянган тонн

	ААНБ-д бий болсон		Өрхөд бий болсон		Импорт		НИЙТ НӨӨЦ
	Энгийн хог хаягдал	Аюултай хог хаягдал	Энгийн хог хаягдал	Аюултай хог хаягдал	Энгийн хог хаягдал	Аюултай хог хаягдал	
2020	598.5	463.8	1 645.6	3.2	1.6	-	2 712.7
2021	727.8	221.2	1 674.7	1.1	1.9	-	2 626.7
2022	744.6	566.3	1 752.9	1.1	2.9	-	3 067.9
2023	769.1	432.8	1 837.9	1.1	1.9	-	3 042.9

2.1.1. ЭНГИЙН ХОГ ХАЯГДАЛ


Улсын хэмжээнд бий болсон энгийн хог хаягдлын хэмжээ 2023 онд 2 607.1 мянган тонн болж, 2022 оноос 109.5 (4.4%) мянган тонноор нэмэгдсэн байна. Энгийн хог хаягдлын хэмжээ нэмэгдэхэд цаас, цаасан бүтээгдэхүүний хаягдал 57.9 (28.2%) мянган тонн, хуванцар бүтээгдэхүүний хаягдал 66.1 (39.4%) мянган тонн, хүнс, био массын төрлийн хаягдал 58.2 (28.7%) мянган тонноор тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Харин автомашины эд ангийн хаягдал 2023 онд 95.4 мянган тонн болж, 2022 оноос 96.5 (50.3%) мянган тонноор буурчээ.

ХҮСНЭГТ 4. ЭНГИЙН ХОГ ХАЯГДАЛ, хог хаягдлын төрлөөр, мянган тонн

Хог хаягдлын төрөл	2022			2023		
	Нийт	ААНБ	Өрх	Нийт	ААНБ	Өрх
Нийт	2 497.5	744.6	1 752.9	2 607.1	769.1	1 837.9
Цаас, цаасан бүтээгдэхүүний хаягдал	205.6	67.4	138.2	263.5	92.9	170.6
Шил, шилэн бүтээгдэхүүний хаягдал	130.7	28.3	102.4	155.9	38.2	117.7
Метал бүтээгдэхүүний хаягдал	124.0	33.4	90.6	137.7	37.5	100.2
Хуванцар бүтээгдэхүүний хаягдал	167.6	38.9	128.7	233.7	49.5	184.2
Барилгын хог хаягдал	279.9	102.2	177.7	269.9	106.8	163.0
Хүнс, био массын төрлийн хаягдал	202.6	43.5	159.1	260.9	65.0	195.9
Цахилгаан барааны хаягдал	87.8	14.0	73.8	53.8	11.3	42.5
Автомашины эд анги	191.9	32.1	159.8	95.4	30.9	64.5
Бусад хаягдал	1 107.4	384.9	722.5	1 136.4	337.0	799.3

2023 оны байдлаар энгийн хог хаягдлын 70.5 хувийг өрх, 29.5 хувийг ААНБ үүсгэсэн байна.

ЗУРАГ 1. ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН БҮТЭЦ, хувиар, 2023 он



Энгийн хог хаягдлын 2023 оны бүтцийг авч үзвэл барилгын хог хаягдал 10.4 хувь, цаас, цаасан бүтээгдэхүүний хаягдал 10.1 хувь, хүнс, био массын төрлийн хаягдал 10.0 хувь, хуванцар бүтээгдэхүүний хаягдал 9.0 хувь, шил, шилэн бүтээгдэхүүний хаягдал 6.0 хувь, метал бүтээгдэхүүний хаягдал 5.3 хувь, автомашины эд ангийн хаягдал 3.7 хувь, цахилгаан барааны хаягдал 2.1 хувийг харин бусад хог хаягдал 43.6 хувийг эзэлж байна. Бусад хог хаягдал өндөр хувьтай байгаа нь манай улсын хог хаягдлыг ангилан ялгах байдал хангалтгүй байгааг илтгэж байна.

2.1.2. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ

Тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг аюултай хог хаягдал гэдэг.


Аюултай хог хаягдлын хэмжээ 2023 онд 433.9 мянган тонн болж, 2022 онтой харьцуулахад 133.5 (23.5%) мянган тонноор буурсан байна. Аюултай хог хаягдлын хэмжээ буурахад эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагаас үүссэн хог хаягдал 138.1 (46.8%) тонноор буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Харин цахилгаан станц, дулааны үйлдвэрлэлээс үүссэн аюултай хог хаягдлын хэмжээ 2023 онд өмнөх оноос 1.8 (1.0%) мянган тонн, уул уурхайн үйл ажиллагаанаас үүссэн аюултай хог хаягдал 2.5 (2.9%) мянган тонн, арьс шир, үслэг, ноос ноолуур, ээрмэлийн үйлдвэрлэлийн аюултай хог хаягдал 0.1 (28.7%) мянган тонноор тус тус өсчээ.

ХҮСНЭГТ 5. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ, эх үүсвэрээр, мянган тонн

Хог хаягдал, эх үүсвэрээр	2020	2021	2022	2023
Нийт	467.0	222.3	567.4	433.9
Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдал	358.1	5.4	294.8	156.7
Боловсрол, шинжлэх ухааны байгууллагын хог хаягдал	0.0	0.1	0.0	0.1
Цахилгаан станц, дулааны үйлдвэрлэлийн хог хаягдал	99.9	124.6	185.9	187.7
Уул уурхайн үйл ажиллагааны хог хаягдал	3.4	90.0	84.9	87.4
Химийн бодисын үйлдвэрлэлийн хог хаягдал	0.1	0.0	0.0	0.0
Хог хаягдал боловсруулах үйлдвэрлэлийн хог хаягдал	0.2	0.3	0.0	0.0
Барилга, барилгын материал үйлдвэрийн хог хаягдал	0.2	0.0	0.0	0.2
Ахуйн хэрэглээний хог хаягдал	3.2	1.1	1.1	1.1
Арьс шир, үслэг, ноос ноолуур, ээрмэлийн үйлдвэрлэлийн хог хаягдал	0.2	0.3	0.3	0.4
Бусад хог хаягдал	1.6	0.6	0.4	0.3

ЗУРАГ 2. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН БҮТЭЦ, эх үүсвэр, дүнд эзлэх хувиар



Аюултай хог хаягдлын бүтцээс харахад 2020 онд нийт аюултай хог хаягдлын 76.7 хувь нь эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагаас, 21.4 хувь нь цахилгаан станц, дулааны үйлдвэрлэлээс үүсч байсан бол 2023 онд 36.1 хувь нь эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагаас, 43.3 хувь нь цахилгаан станц, дулааны үйлдвэрлэлээс, 20.1 хувь нь уул уурхайн үйл ажиллагаанаас үүссэн байна.

2.1.3. ХОГ ХАЯГДАЛ, эдийн засгийн салбараар

Хог хаягдлын дансны нэг гол зорилго нь хог хаягдлыг эдийн засгийн салбаруудаар харуулах явдал юм. Энгийн болон аюултай хог хаягдлын бүтэц салбаруудад харилцан адилгүй байна.

Энгийн хог хаягдлын хувьд уул уурхай, барилга, боловсруулах үйлдвэрлэл, цахилгаан, хий, уур, тээвэр, агуулахын салбарууд бусад салбартай харьцуулахад илүү их хог хаягдлыг үйлдвэрлэж байна. Тухайлбал, 2023 оны хувьд энгийн хог хаягдлын 36.5 хувь нь барилгын салбарт, 17.1 хувь нь уул уурхай, олборлох салбарт, 10.9 хувь нь тээвэр, агуулахын салбарт ногдож байна.

Харин аюултай хог хаягдлын хувьд уул уурхай, олборлолт, цахилгаан, хий, уур, эрүүл мэндийн салбарууд хамгийн өндөр хувийн жин эзэлж байна.

ХҮСНЭГТ 6. ААНБ-Д БИЙ БОЛСОН ХОГ ХАЯГДАЛ, эдийн засгийн салбараар, мянган тонн

Эдийн засгийн салбар	2020		2021		2022		2023	
	Энгийн	Аюултай	Энгийн	Аюултай	Энгийн	Аюултай	Энгийн	Аюултай
Нийт	598.5	463.8	727.8	221.2	744.6	567.4	769.1	432.8
ХАА	0.1	-	0.2	-	1.1	-	0.1	0.0
Уул уурхай	153.1	3.4	126.1	90.0	160.5	84.9	131.6	87.4
Боловсруулах	24.4	0.3	12.0	0.3	21.3	0.3	13.9	0.4
Цахилгаан, хий, уур	28.5	99.9	36.6	124.6	58.6	185.9	37.2	187.7
Усан хангамж,	2.8	0.2	9.2	0.3	21.1	0.0	32.2	0.0
Барилга	162.6	0.2	290.5	0.0	291.6	0.0	280.7	0.2
Худалдаа	18.1	-	53.4	-	36.0	1.1	18.9	0.0
Тээвэр, агуулах	86.9	-	26.2	-	52.8	-	83.5	0.0
Зочид буудал, зоогийн газар	0.6	-	1.4	-	5.6	-	11.7	0.0
Бусад	121.3	359.7	172.1	6.0	96.0	295.2	159.4	157.2

2.2. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН НИЙТ АШИГЛАЛТ

Нийт үүссэн хог хаягдлын 2 243.7 (73.7%) мянган тонныг 2023 онд ландфиллд булж, 151.1 (5.0%) мянган тонныг шатааж, 271.1 (8.9%) мянган тонныг бусад аргаар (биологийн аргаар устгах, химийн болон физикийн аргаар боловсруулах, халдваргүйжүүлэх, саармагжуулж хадгалах гэх мэт) устгаж, 196.3 (6.5%) мянган тонныг дахин боловсруулж, 178.0 (5.8%) мянган тонныг байгальд шууд хаясан байна. Харин 2.7 (0.1%) мянган тонн хог хаягдлыг экспортод гаргажээ.

ХҮСНЭГТ 7. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН НИЙТ АШИГЛАЛТ, мянган тонн

	Ландфилл /газарт булшлах/	Шатаах	Бусад	Дахин боловсруулах, дахин ашиглах	Хатуу хог хаягдлын экспорт	Байгаль орчинд орох урсгал	НИЙТ АШИГЛАЛТ
2020	1 984.2	46.9	375.0	285.2	0.5	20.8	2 712.7
2021	1 910.7	236.5	210.4	193.6	0.6	74.8	2 626.7
2022	2 238.1	263.3	270.6	235.2	2.7	58.0	3 067.9
2023	2 243.7	151.1	271.1	196.3	2.7	178.0	3 042.9

Нийт үүссэн хог хаягдлын ашиглалтыг хог хаягдлын төрлөөр авч үзвэл 2022 онд энгийн хог хаягдлын 2052.7 (82.1%) мянган тонныг ландфиллд булж, 225.8 (9.0%) мянган тонныг дахин боловсруулсан бол 2023 онд 2106.6 (80.7%) мянган тонныг ландфиллд булж, 188.8 (7.2%) мянган тонныг дахин боловсруулсан байна.

Харин аюултай хог хаягдлын 185.4 (32.7%) мянган тонныг 2022 онд ландфиллд булж, 102.0 (18.0%) мянган тонныг шатааж, 270.6 (47.7%) мянган тонныг бусад аргаар (биологийн аргаар устгах, химийн болон физикийн аргаар боловсруулах, халдваргүйжүүлэх, саармагжуулж хадгалах гэх мэт) устгасан бол 2023 онд 137.1 (31.6%) мянган тонныг ландфиллд булж, 18.2 (4.2%) мянган тонныг шатааж, 271.1 (62.5%) мянган тонныг бусад аргаар (биологийн аргаар устгах, химийн болон физикийн аргаар боловсруулах, халдваргүйжүүлэх, саармагжуулж хадгалах гэх мэт) устгасан байна.

ХҮСНЭГТ 8. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН НИЙТ АШИГЛАЛТ, хог хаягдлын төрлөөр, мянган тонн

	2021			2022			2023		
	Нийт	Энгийн	Аюултай	Нийт	Энгийн	Аюултай	Нийт	Энгийн	Аюултай
НИЙТ АШИГЛАЛТ	2626.7	2404.4	222.3	3067.9	2500.4	567.4	3042.9	2609.0	433.9
Ландфилл /газарт булшлах/ Шатаах	1910.7	1907.9	2.8	2238.1	2052.7	185.4	2243.7	2106.6	137.1
Бусад	236.5	234.4	2.1	263.3	161.2	102.0	151.1	133.0	18.2
Дахин боловсруулах, дахин ашиглах	210.4	-	210.4	270.6	-	270.6	271.1	-	271.1
Хатуу хог хаягдлын экспорт	193.6	186.6	7.0	235.2	225.8	9.4	196.3	188.8	7.5
Байгаль орчинд орох урсгал	0.6	0.6	-	2.7	2.7	-	2.7	2.7	-
	74.8	74.8	-	58.0	58.0	-	178.0	178.0	-

2.2.1. ДАХИН АШИГЛАСАН, БОЛОВСРУУЛСАН ЭНГИЙН ХОГ ХАЯГДАЛ

Хог хаягдлын тодорхой хэсгийг дахин ашиглаж, дахин боловсруулдаг. Хог хаягдлыг ашиглан шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг дахин боловсруулж байна гэж хэлнэ. Дахин ашиглах гэдэг нь тухайн зүйлийг анхны зориулалтаар нь эсвэл өөр зорилгоор ашиглах үйлдлийг хэлнэ.


Дахин ашигласан, боловсруулсан энгийн хог хаягдлын хэмжээ 2022 онд 225.8 мянган тонн байсан бол 2023 онд 188.8 мянган тонн болж 37.0 мянган тонн буюу 16.4 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 9. ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН ДАХИН АШИГЛАЛТ, БОЛОВСРУУЛАЛТ, хог хаягдлын төрлөөр, мянган тонн

Хог хаягдлын төрөл	2020	2021	2022	2023
Нийт	272.9	186.6	225.8	188.8
Цаас, цаасан бүтээгдэхүүний хаягдал	42.7	55.3	30.2	30.2
Шил, шилэн бүтээгдэхүүний хаягдал	19.0	5.1	19.6	89.2
Метал бүтээгдэхүүний хаягдал	17.9	30.6	34.9	34.9
Хуванцар бүтээгдэхүүний хаягдал	16.0	39.5	42.5	42.5
Барилгын хог хаягдал	9.0	17.1	3.0	16.6
Хүнс, био массын төрлийн хаягдал	12.4	9.3	19.3	19.3
Цахилгаан барааны хаягдал	0.9	0.5	2.4	2.4
Автомашинны эд анги	43.5	51.4	13.4	7.4
Бусад хаягдал	25.2	16.9	23.5	35.1

Дахин ашигласан, боловсруулсан хог хаягдлын бүтцийг хог хаягдлын төрлөөр авч үзвэл 2023 онд хуванцар бүтээгдэхүүний хаягдал 22.5 хувь, метал бүтээгдэхүүний хаягдал 18.5 хувь, цаас, цаасан бүтээгдэхүүний хаягдал 16.0 хувь, шил, шилэн бүтээгдэхүүний хаягдал 10.4 хувь, хүнс, био массын төрлийн хаягдал 10.2 хувь, автомашинны эд ангийн хаягдал 7.1 хувь, барилга, цахилгаан барааны болон бусад хог хаягдал 15.3 хувийг тус тус эзэлж байна.

ЗУРАГ 3. ДАХИН БОЛОВСРУУЛСАН, АШИГЛАСАН ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН БҮТЭЦ, хувиар



ГУРАВ. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хог хаягдлыг бууруулах, сөрөг нөлөөнөөс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх зэрэг үндэсний бодлого, холбогдох хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрүүдийг боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх зэрэгт хатуу хог хаягдлын дансны үр дүнг ашиглана. Мөн хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах үйлдвэржилтийн бодлого боловсруулах суурь мэдээлэл болно.

3.1. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНААС ТООЦСОН ТХЗ-ЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хатуу хог хаягдлын дансыг байгуулснаар “Тогтвортой хөгжлийн зорилго 2030”-ын 11.6, 12.4, 12.5 зорилтыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд (11.6.1, 12.4.2, 12.5.1)-ийг тооцох боломж бүрдэж байна.



- [ТХЗ Зорилт 11.6](#) 2030 он гэхэд агаарын чанар, хотын болон хог хаягдлын менежментийн асуудалд онцгой анхаарлаа хандуулах замаар хотуудын нэг хүнд ногдох байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах.
- [Шалгуур үзүүлэлт 11.6.1](#) Хот суурин газарт бий болсон хатуу хог хаягдлаас эцсийн боловсруулалт хийгдсэн хатуу хог хаягдлын эзлэх хувь.



- [ТХЗ Зорилт 12.4](#) 2020 он гэхэд хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын баримт бичигт нийцүүлэн химийн бодис болон бүх төрлийн хог хаягдлыг амьдралынх нь мөчлөгийн хугацаанд байгаль орчинд ээлтэй байдлаар зохицуулах.



- [Шалгуур үзүүлэлт 12.4.2](#) Цуглуулсан нийт аюултай хог хаягдалд эцсийн боловсруулалт хийсэн аюултай хог хаягдлын эзлэх хувь.
- [ТХЗ Зорилт 12.5](#) 2030 он гэхэд хог хаягдлаас сэргийлэх, түүнийг бууруулах дахин боловсруулах, дахин хэрэглэх замаар хог хаягдал бий болгож буй хэмжээг үлэмж хэмжээгээр бууруулах.
- [Шалгуур үзүүлэлт 12.5.1](#) Хог хаягдлын дахин боловсруулалтын түвшин.

Хатуу хог хаягдлын эцсийн боловсруулалт гэдэгт ландфиллд булшлах, шатаах, бусад аргаар устгах үйл ажиллагааг хамруулна. Хог хаягдлын дахин боловсруулалтад хог хаягдлыг боловсруулж шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хог хаягдлын дахин ашиглалтыг хамруулна.

ХҮСНЭГТ 10. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНААС ТООЦСОН ТХЗ-ЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020	2021	2022	2023
11.6.1 Хот суурин газарт бий болсон хатуу хог хаягдлаас эцсийн боловсруулалт хийгдсэн хатуу хог хаягдлын эзлэх хувь	хувь	88.7	89.8	90.4	87.6
12.4.2 Нийт аюултай хог хаягдалд эцсийн боловсруулалт хийсэн аюултай хог хаягдлын эзлэх хувь	хувь	97.4	96.9	98.3	98.3
12.5.1 Хог хаягдлын дахин боловсруулалтын түвшин	хувь	10.5	7.4	7.7	6.5

ДҮГНЭЛТ

Хатуу хог хаягдлын 2020-2023 оны дансны үр дүнгээс:

- Хатуу хог хаягдлын нийт хэмжээ 2020 онд 2712.7 мянган тонн, 2021 онд 2626.7 мянган тонн, 2022 онд 3067.9 мянган тонн, 2023 онд 3042.9 мянган тонн болж нэмэгдэж байна.
- 2020-2023 оны дунджаар хатуу хог хаягдлын 39.5 хувийг эдийн засгийн салбарууд, 60.4 хувийг өрх үүсгэсэн бол 0.1 хувийг импортоор оруулсан байна.
- Нийт хог хаягдалд энгийн хог хаягдал 85.2 хувь, аюултай хог хаягдал 14.8 хувийг эзэлж байна.
- Аюултай хог хаягдлын дийлэнх нь цахилгаан, дулаан үйлдвэрлэл, эрүүл мэнд болон уул уурхайн үйл ажиллагаанаас бий болж байна. Тухайлбал, 2020 онд нийт аюултай хог хаягдлын 76.7 хувь нь эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагаас, 21.4 хувь нь цахилгаан станц, дулааны үйлдвэрлэлээс үүсч байсан бол 2023 онд 36.1 хувь нь эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагаас, 43.3 хувь нь цахилгаан станц, дулааны үйлдвэрлэлээс, 20.1 хувь нь уул уурхайн үйл ажиллагаанаас үүссэн байна.
- 2020-2023 оны дунджаар нийт хог хаягдлын 73.2 хувийг ландфиллд булж, 6.1 хувийг шатааж, 7.9 хувийг дахин боловсруулсан бол 2.9 хувийг байгальд шууд хаясан байна.
- Дахин ашигласан, боловсруулсан хог хаягдлын бүтцийг хог хаягдлын төрлөөр авч үзвэл 2020-2023 онд дунджаар цаас, цаасан бүтээгдэхүүний хаягдал 22.2 хувь, метал бүтээгдэхүүний хаягдал 15.6 хувь, хуванцар бүтээгдэхүүний хаягдал 15.5 хувь, автомашины эд ангийн хаягдал 14.9 хувь, шил, шилэн бүтээгдэхүүний хаягдал 8.2 хувь, хүнс, био массын төрлийн хаягдал 6.2 хувь, барилгын хог хаягдал 4.7 хувь, цахилгаан барааны болон бусад хог хаягдал 12.7 хувийг тус тус эзэлж байна.

Дансны үр дүнгээс харахад манай улсад нийт хог хаягдлын ихэнхийг хогийн төвлөрсөн цэгт булшилж устгаж байна. Цаашид нөөцийг хэмнэх, байгальд бий болох дарамтыг бууруулахын тулд хог хаягдлыг ангилж, дахин боловсруулах үйл ажиллагааг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

ХАВСРАЛТ ХҮСНЭГТ



Дээрх QR кодыг уншуулж, эсхүл **ЭНД**
дарж хавсралт хүснэгтийг татаж авна уу

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Хатуу хог хаягдлын дансыг байгуулах аргачлал, 2021 он, ҮСХ
- Байгаль орчин-эдийн засгийн дансны систем - Ерөнхий хүрээ, 2012
- БОУАӨЯ-ны 2020-2023 оны “Энгийн хатуу хог хаягдлын жилийн мэдээ - БОХ 6.1”, “Аюултай хог хаягдлын жилийн мэдээ - БОХ 6.2”, “Хог хаягдлын дахин ашиглалт, боловсруулалтын жилийн мэдээ - БОХ 6.3” маягтаар цуглуулсан мэдээлэл
- ААНБ-ын 2020-2023 оны өртөг, зардлын мэдээлэл
- ГЕГ-ын мэдээллийн бааз, хог хаягдлын экспорт, импортын мэдээлэл
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, <http://www.1212.mn/>